

ЭЛЧИНГИЙН ЦОМ 2025
ТАЕКВОНДОГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчлах
- Монгол улсад олимпын таеквондогийн спортыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах
- Баг тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Дэмжигч	БНСУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яам
Зохион байгуулагч	Монголын таеквондогийн холбоо
Холбоо барих утас	7015-5500, 8619-0073
Имэйл	mongoliatekwondo@gmail.com
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
09-р сарын 05-17	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
09-р сарын 23	Техникийн зөвлөгөөн	Монголын таеквондогийн холбоо
09-р сарын 24-25	Тэмцээн	Бөхийн өргөө

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.

ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдал** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.

1. Оролцогч тамирчин Монголын таеквондогийн холбоо болон Куккивоны ямар нэг зэрэг хар бүс, дантай байна
2. Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна
3. А ангиллын тамирчид заавал пүмсэ тобок өмсөнө

Багт тавигдах шаардлага:

1. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байна
2. Оролцогч байгууллага нь татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх

Дасгалжуулагчид тавигдах шаардлага:

1. Монголын таеквондогийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчдыг дэвжээнд авч гарах эрхтэй
2. Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас өмсөх шаардлагатай
3. Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг
4. Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно

1. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

I. Дэлхийн таеквондогийн холбооны дүрмийн дагуу хасагдах системээр явагдана.

II. Тэмцээнд оролцогчид хүйс, насаар хязгаарлагдахгүй бол дээд тал нь хоёр ангилалд өрсөлдөх боломжтой.

III. Насны хувьд:

Үндсэн пүмсэ:

- Бага нас 8-9 нас

- Бага нас 10-11 нас

- Өсвөр үе 12-14 нас

- Залуучууд 15-17 нас

- Насанд хүрэгч 18-30 нас

- Мастер 31 болон түүнээс дээш насны ангилалд тэмцээн явагдана.

- Насыг сараар бус жилээр тооцно. Жишээлбэл: Залуучуудын ангилалд өрсөлдөх тамирчин нь 2008.01.01-2010.12.31 хооронд төрсөн байна.

Чөлөөт пүмсэ:

- 17 нас хүртэлх
- 18 болон түүнээс дээш нас

IV. Бүсний ангилал:

- А ангилалд хар бүс, куккивоны дантай тамирчид
- В ангилалд хөх, улаан бүстэй тамирчид
- С ангилалд шар, ногоон бүстэй тамирчид тус тус оролцох эрхтэй.
- Чөлөөт пүмсэ төрөлд насны ангилал байх боловч бүсний ангилалгүй өрсөлдөнө.
- Насанд хүрэгчид, мастер ангилалд бүсний ангилалгүй өрсөлдөнө.

2. ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

- Үндсэн пүмсэ: 90 секунд хүртэл
- Чөлөөт пүмсэ: 90-100 секунд хооронд
- Завсарлага: Эхний пүмсэ болон хоёр дахь пүмсэ хоорондын зай хамгийн багадаа 30 секунд

3. ГҮЙЦЭТГЭХ ДАСГАЛ:

Үндсэн пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан
Эрэгтэй баг (3 эрэгтэй)
Эмэгтэй баг (3 эмэгтэй)
Холимог хос (1 эрэгтэй, 1 эмэгтэй)

Чөлөөт пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан
Холимог хос (1 эрэгтэй, 1 эмэгтэй)
Холимог баг (5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба эрэгтэй, эмэгтэй тамирчдын тоо тус бүр хамгийн багадаа 2, 2 байх ёстой)

Үндсэн пүмсэ төрлийн холимог хос, багийн ангилалд зөвхөн өөрийн бүсний ангиллын тамирчидтай хамтарна.

Нас	Ангилал	Урьдчилсан шат	Хагас шигшээ, шигшээ шат
Бага нас	А ангилал	Таегүк 4,5,6,7,8 жан, Корёо	
	В ангилал	Таегүк 2, 4 жан	Таегүк 3, 5 жан
	С ангилал	Таегүк 1 жан	Таегүк 2, 3 жан
Өсвөр үе	А ангилал	Таегүк 5,6,7,8 жан, Корёо, Гимган	
	В ангилал	Таегүк 3, 5 жан	Таегүк 4, 6 жан
	С ангилал	Таегүк 1 жан	Таегүк 2, 3 жан
Залуучууд	А ангилал	Таегүк 6,7,8 жан, Корёо, Гимган, Тебек	
	В ангилал	Таегүк 4,6 жан	Таегүк 5, 7 жан
	С ангилал	Таегүк 1 жан	Таегүк 2, 3 жан
Насанд хүрэгч, Мастер	Ангилалгүй	Таегүк 7,8 жан, Корёо, Гимган, Тебек, Пёнвон	

Тэмцээн хасагдах системээр явагдана. А ангиллын гүйцэтгэх 2 пүмсэг санамсаргүй байдлаар сонгож, тэмцээний өмнөх багийн ахлагч нарын хурал дээр мэдэгдэнэ.

Чөлөөт пүмсэ:

Тамирчид таеквондогийн техник дээр тулгуурлан хөгжим, бүжиг дэглэлт бүхий чөлөөт пүмсэ гүйцэтгэнэ. Гүйцэтгэх техникүүд нь таеквондогийн хүрээнд байх ёстой.

Заавал гүйцэтгэх техникүүд:

Дидкүби соги, Хагдари соги, Боем соги

Дараах өшиглөлтүүдийг дарааллын дагуу гүйцэтгэнэ.

1. Үсрээд юбчаги
2. Үсрээд гурваас дээш өшиглөлт
3. Эргэлттэй өшиглөлт /дангаар нь хийнэ/
4. Тулааны өшиглөлт /угсраа таваас долоон өшиглөлт/
5. Акробат /заавал өшиглөлт агуулсан байх/

Өөрсдийн зохиосон пүмсэг 90-100 секундын хугацаанд хөгжмийн аянд хийж гүйцэтгэнэ. Заасан хугацаанаас бага хугацаанд эсвэл хугацаа хэтэрвэл оноо хасагдана. Заавал хийх техникүүдийг оруулсан байх бөгөөд уран сэтгэмж, хөдөлгөөний эвсэл, аяны зохицол, дэвжээ эзэмшилт болон өндөр градустай техникийг харж дүгнэнэ.

Холимог багийн төрөлд техникийн гурван ур чадвар дээр суурилан хатуу биетийг хугалах шаардлагатай. (эргэлттэй өшиглөлт, тулааны хэв маяг буюу угсраа өшиглөлт, акробатын эргэлттэй өшиглөлт)

Хатуу биет болон акробатын техник гүйцэтгэхэд ашиглах саваа болон хатуу биетийг багууд өөрсдөө хариуцна. Хатуу биетийг холимог багийн 5 гишүүн дотор л барих эрхтэй. Хатуу биетийг дэвжээнээс гадна хугалахыг тооцохгүй.

4. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болон www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.
- II. Бүртгэлийн системд тамирчдыг бүртгүүлэхдээ сүүлийн 6 сард авахуулсан цээж зургийг ашиглана.
- III. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар шилжүүлнэ.

5. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ, БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. Бүртгэлийн хугацаа: 2025 оны 09-р сарын 05-17-ны өдрийн 18:00 цаг хүртэл
Нэг төрөлд оролцох тамирчны дэвжээний төлбөр:
 - Улаанбаатар хотын тамирчид тамирчид 50.000 (тавин мянга) төгрөг
 - Улаанбаатар хотоос 1000 км дотогш 40.000 (дөчин мянга) төгрөг
 - Улаанбаатар хотоос 1000 км гадагш Үнэ төлбөргүй (нэг төрөлд оролцох бол)Хоёр төрөлд оролцох тамирчны хувьд дэвжээний төлбөр дээр 10.000 (арван мянга) төгрөг нэмэгдэнэ.

6. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- I. Хувь тамирчин
Насны ангилалд тус бүрд 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан шагнаж урамшуулна.
- II. Баг
Багийн дүнг медалийн чанараар дүгнэнэ.
Багийн дүнг зөвхөн А ангилалд тооцох ба медалийн чанараар эрэгтэй болон эмэгтэй ангилалд тус бүр эхний гурван байр эзэлсэн багуудыг цом, медаль, мөнгөн шагналаар урамшуулна.
Насанд хүрэгч, мастерын ангиллыг багийн дүнд оруулна.
Чөлөөт пүмсэ төрөлд медаль хүртсэн тамирчдын медаль багийн дүнд тооцогдохгүй.
- III. Шилдэг дасгалжуулагч, шилдэг шүүгч, шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин тус бүр 1 шалгаруулах шагнаж урамшуулна.

7. ӨМСГӨЛ:

- А ангилалд өрсөлдөх тамирчин нь заавал пүмсэ тобок өмсөх шаардлагатай.

Монгол улсад хэрэглэгдэх таеквондогийн өмсгөлийн стандарт



ПҮМСЭ

Пүмсэ буюу тоот дасгалын тамирчид Ү төрлийн задгай энгэртэй өмсгөл өмсөнө. 15 хүртэлх насны тамирчид хүйснээс хамааран улаан болон хөх өнгийн өмд, улаан, хар судал бүхий энгэрийн эмжээр бүхий дээд өмсгөл өмсөнө. Өндөр дан (Хар бүс 7-р дан болон түүнээс дээш) болон ахмад настай мастерууд ердийн цагаан өнгөний оронд алтан шар өнгийн өмсгөл өмсөх эрхтэй байдаг байна.



ГҮП, ПҮҮМ ЗЭРЭГ

15 хүртэлх насны тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.
Өмдний тухайд:
Эрэгтэй: Хөх өнгө
Эмэгтэй: Улаан өнгө



ДАН ЗЭРЭГ

16 ба түүнээс дээш настай хар бүстэй тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.
Өмдний тухайд:
Эрэгтэй: Хар өнгө
Эмэгтэй: Саарал өнгө



МАСТЕР

Хар бүс 7-р дан болон түүнээс дээш дантай мастерууд. Мөн түүнчлэн ахмад настай мастер тамирчид Алтан шар өнгийн өмсгөл өмсөнө.

- В, С ангилалд өрсөлдөх тамирчин ердийн тулааны тобок өмсөн оролцож болох хэдий ч Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдана
- Тэмцээний өмсгөлийн стандарт

УРД ТАЛ



АР ТАЛ



8. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ:

1. Багийн ахлагч нар 09-р сарын 23-ны өдөр хуралдана.
2. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -